



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/659

Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Жаргалант сумын Наран баг 1 дүгээр гудамжны 07 тоотод байрлах Бэгзжавын Мөнхжаргал /ПЮ58081078/-ийн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 650.0 метр квадрат газрыг хаягийн мэдээллийн сангийн зургийн дагуу 1025.0 метр квадрат болгон 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Цамбагарав баг 1 дүгээр гудамжны 07 тоотод байрлах Пүрэвийн Улаанхүү /ПП68041917/-ийн эмнэлгийн зориулалттай 250.0 метр квадрат газрыг хаягийн мэдээллийн сангийн зургийн дагуу 817.0 метр квадрат, хаягийг Лааганы 2 дугаар гудамжны 238 тоот болгон 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

3.Эзэмшил газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа иргэнд газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/659 Ch

02 2959